



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар: 24/01/02

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1, 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төвийн 5-р давхарт 502 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 3-р сарын 22-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
 4. Нэмэлт хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
 5. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
 6. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2024 оны 3-р сарын 06-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2024 оны 3-р сарын 26-нд уг зарыг давтан, 2024 оны 3-р сарын 11-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2024 оны 3-р сарын 29 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа

- эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Г.Халиунаа/-г даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
 9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г.Халиунаа, гишүүнээр, А.Ариунболд Тооллогын комиссийн даргаар Х.Мөнгөнцэцэг, гишүүнээр О.Мэндбаяр нарыг тус тус томилсугай.
 10. "Евразиа капитал холдинг ҮЦК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



КАМОЛИДДИН ТАЛИПОВ